



ИНФОГРАФИК: ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Өмнөх сартай харьцуулсан үзүүлэлт





ЭКСПОРТЫН ГОЛ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ХЭМЖЭЭ БОЛОН ДУНДАЖ ҮНЭ

Экспортын гол бүтээгдэхүүний хэмжээ болон дундаж үнийг графикаар оны эцсийн байдлаар харуулав.



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ИНФОГРАФИК- САР ТУТМЫН БУСАД ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЭДИЙН ЗАСАГ ЯМАР БАЙХ ВЭ?- ТААМАГ (ОУЭЗБ)

ДНБ-ий өсөлт: 2022 онд: **6%**,  
Инфляци: 2022 онд: **8.2%**,  
Урсгал тэнцэл: 2022 онд: **-10.2%**-тай байхыг Азийн хөгжлийн банк (АЗХБ) 2021 оны тайланд прогноз хийсэн байна.

Эх сурвалж: <https://bit.ly/30pG2Et>


ДНБ-ий өсөлт: 2022 онд: **7.5%**  
Инфляци: 2021 онд: **7.3%**,  
ДНБ-д эзлэх урсгал тэнцэл: 2022 онд: **-8.5%**- Олон улсын валютын сан (ОУВС)-ийн тайланд дурдсан байна.

Эх сурвалж: <https://bit.ly/3qx1ORq>

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД: УЛСЫН ТӨСӨВ, ВАЛЮТЫН ХАНШ, ИНФЛЯЦ, ГАДААД ХУДАЛДАА

**Төсвийн тэнцэл 5-р сарын байдлаар 539 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.**

Улсын нэгдсэн төсвийн орлого өмнөх жилийн мөн үеэс 53.3 хувиар өссөн бол, зарлага 5 хувиар нэмэгдэж төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 539 тэрбум төгрөгийн алдагдалтай гарав. Төсвийн алдагдал өнгөрсөн оны мөн үеэс 37.8 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна.




**Ам.долларын ханш өмнөх сараас 68.32 төгрөгөөр өсжээ.**

Тавдугаар сард Монголбанкны төгрөгийн ам.доллартай харьцах нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 260 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 68.32 төгрөгөөр өсч 3110.22 төгрөг болов. 5-р сард гадаад валютын нөөц 3.1 тэрбум төгрөг буюу өнгөрсөн сараас -5.69 оны эхнээс 31.05 хувиар буурч, өнгөрсөн оны мөн үеэс 35.92 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



**Инфляцын түвшин 15.1%**

Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 5-р сарын байдлаар өмнөх сараас 1.4 хувиар нэмэгдэж, өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар, оны эхнээс 7.9 хувь өсөв. Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ 2022 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 15.1 хувиар өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 18 хувь, согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 9 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 13.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 10.7 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнэ дүнгээрээ 16.1 хувь, тээврийн бүлгийн үнэ дүнгээрээ 25.6 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.



**Гадаад худалдааны тэнцэл 946 сая.ам долларын ашигтай гарав.**

2022 оны тавдугаар сард нийт барааны эргэлт 7221 тэрбум төгрөг буюу өмнөх оны мөн үеэс 21 хувиар өссөн бол экспорт өмнөх сараас 22 хувь, импорт өмнөх оны мөн үеэс 20 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 946 сая ам.долларын ашигтай гарав.



## 5-Р САРЫН ОНЦЛОХ: ХАДГАЛАМЖ

Эх сурвалж: [www.1212.mn](http://www.1212.mn)

Нийт хадгаламж 2022 оны 5-р сард 18.4 их наяд төгрөг болж өмнөх сараас 321.9 тэрбум төгрөг буюу 1.8 хувиар өссөн бол өнгөрсөн оны мөн үеэс 3 хувиар буюу 354.6 тэрбум төгрөгөөр өсөв. Тус сард төгрөгийн хадгаламж 14014.7 тэрбум төгрөг буюу өмнөх сараас 2.1 хувиар, валютын хадгаламж 4390.5 тэрбум төгрөг болж өмнөх сараас 0.7 хувиар нэмэгдэв. Үүнээс төгрөгийн хадгаламж 76 хувь, валютын хадгаламж 24 хувийг эзэлж байна. Харин өнгөрсөн оны мөн үеэс төгрөгийн хадгаламж 5.8 хувиар буурсан бол валютын хадгаламж 4.3 хувиар нэмэгджээ.

## САРЫН ОНЦЛОХ

**МОНГОЛ УЛСЫН ЗЭЭЛЖИХ ЗЭРЭГЛЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ТОГТВОРТОЙ ХЭВЭЭР БАТАЛГААЖУУЛАВ.**

- Олон улсын "Фитч" агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийн үнэлгээг "В", төлөвийг "Тогтвортой" хэвээр үлдээснийг зарлав. Тус байгууллагын дүгнэлтээр Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал дараах үндэслэлээр тогтвортой байгаа гэдгийг хэвлэлийн мэдээлэлд тэмдэглэжээ. Үүнд: Монгол Улсын засаглалын үзүүлэлтүүд, нэг хүнд ногдох орлого нь "В" түвшинтэй бусад орнуудтай харьцуулахад өндөр байна. Мөн дунд хугацаанд эдийн засгийн өсөлт таатай төлөвтэй байна гэж үзэв.

**НЭГ АЖИЛЧИНД НОГДОХ ДНБ ОНЫ ЭХНИЙ УЛИРАЛД 10.2 ХУВИАР БАГАСАВ**

- Нэг ажиллагчид ногдох ДНБ (2015 оны зэрэгцүүлэх үнээр) энэ оны эхний улиралд 4.3 сая төгрөг боллоо. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 490.1 (10.2 хувь) мянган төгрөгөөр багассаныг Үндэсний статистикийн хорооноос мэдээлэв. Томсгосон 4 салбараар авч үзвэл, нэг ажилчинд ногдох ДНБ буюу хөдөлмөрийн бүтээмж энэ оны эхний улиралд өмнөх оны мөн үеийнхээс хөдөө аж ахуйн салбарт нэмэгдэж, уул уурхай олборлолт, аж үйлдвэр, барилга, үйлчилгээний салбарт багассан байна.

Эх сурвалж:

- Статистикийн бюллетень, 5-р сар 2022 он, Үндэсний статистикийн хороо
- Статистикийн бюллетень, 5-р сар 2022 он, Монголбанк
- [www.1212.mn](http://www.1212.mn), [www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn), [www.montsame.mn](http://www.montsame.mn)